



Хэвлэлийн мэдээ
2022 оны 3-р сарын 29

Холбоо барих
(9909-1557)

АмЧам Монгол “Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдэвт дугуй ширээний уулзалт зохион байгууллаа

Улаанбаатар хот – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим нь 2022 оны 3-р сарын 29-ний өглөө 10:00 цагт “Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдвээр дугуй ширээний уулзалтыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү цахим дугуй ширээний уулзалтад Ази Номхон далайн бүсийн АмЧамын байгууллагуудын тэргүүн ноён. Стивен Окун, БНХАУ дахь Америкийн Худалдааны Танхимын Ерөнхийлөгч ноён. Майкл Харт, Сингапур дахь Америкийн Худалдааны Танхимын Харилцаа Холбооны Ажлын хэсгийн дэд тэргүүн бөгөөд AT&T, Warner Media компанийн гадаад харилцаа хариуцсан захирал ноён. Жаред Доуэрти, болон Тайланд дахь Америкийн Худалдааны Танхимын ТУЗ-ын гишүүн бөгөөд Tractus Asia компанийн захирал ноён Жон Эванс нар панелистээр оролцлоо.

Энэ удаагийн хуралд АмЧам Монголын 30 орчин гишүүн байгууллагын төлөөлөл оролцож сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүллээ.

Дугуй ширээний ерөнхий сэдэв нь геополитик, улс төрийн ээдрээтэй өнөөгийн нөхцөл байдалд Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, АНУ-ын энэ бүс нутагт баримтлах бодлого, үүнийг цаг үеийн бэрхшээлүүдтэй үед хэрхэн хадгалж, хамгаалж Америкийн бизнесүүдийн эрх ашгийг хамгаалах, худалдааны болон татварын бодлогын үр нөлөө, хоёр талт болон олон талт гэрээ хамтын ажиллагааны үр дүн зэрэг олон ач холбогдолтой сэдвүүдээр ярилцлаа.



Ноён Стивен Окун, Ази Номхон далайн бүсийн
АмЧам байгууллагуудын тэргүүн

Дугуй ширээний панелистууд цаг үеийн асуудлууд дээр өөр өөрийн мэргэжлийн тайлбаруудыг хийж илэн далангуй санал солилцлоо. Европт үүссэн нөхцөл байдал, тэр дундаа Украин дахь дайны эдийн засгийн үр нөлөө нь бүхий л бизнесийн салбарт нөлөөлж буй тухай ноён Стивен Окун хэлэхдээ “Бид энэ үеийн хамгийн том ул мөр үлдээх үйл явдлын гэрч болж байна. Үүний уршиг нь бизнесийн салбарт олон жилээр үргэлжлэх” талтайг анхааруулж хэллээ. Тэрээр ийм үед улс орнууд цэрэг улс төр, эдийн засгийн эвсэл, холбоод нэгдэж хамтрах үйл явц Европт илүү идэвхжихийн хэрээр Ази Номхон далайн орнуудад бодлогоо эргэж харах, алдагдал хохирлыг аль болох бага байлгах тал дээр ажиллах шаардлагатай байгааг онцоллоо.

БНХАУ дахь Америкийн Худалдааны Танхимын ерөнхийлөгч ноён Майкл Харт “Бүс нутгийн хамтын ажиллагааны бодлого, хууль эрх зүйн орчин нь сайтар боловсруулагдсан боловч хөрсөн дээр хэрхэн буух тал дээр анхааралтай байхыг тэмдэглэв. Бодлого нь зөвхөн баримт бичгийн түвшинд бус амьдрал дээр хэрхэн хэрэгжих, түүнийг өдөр тутамд бизнесүүд хэрхэн хүлээн авах нь нэн чухал байхыг санууллаа. Монгол шиг хөгжиж буй орнуудын хувьд инновацид суурилсан бизнесийг илүү

дэмжих, нөгөө талаас эдийн засгийн чөлөөт бүс байгуулж хөрөнгө оруулалт татаж тодорхой салбараа хөгжүүлэх боломжтой юм. Түүнчлэн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хөгжлийн чиг хандлагыг чиглүүлэх нь бүс нутгийн хөгжилд том хувь нэмэр болохыг тайлбарлалаа.



Ноён Жаред Дуэрти, Сингапур дахь Америкийн Худалдааны Танхимын Харилцаа Холбооны Ажлын хэсгийн дэд тэргүүн бөгөөд AT&T, Warner Media компанийн гадаад харилцаа хариуцсан захирал

Сингапур дахь Америкийн Худалдааны Танхимын Харилцаа Холбооны Ажлын хэсгийн дэд тэргүүн ноён Жаред Дуэрти тайлбарлахдаа “Цахим шилжилтийн далайцтай үйл явц нь цар тахлын үеэр урьд өмнө үзэгдээгүйгээр өссөнийг онцолж, цаашид бизнесийг удирдан авч явах нэгэн салшгүй шинэ чиг хандлага болж” байгааг цохон тэмдэглэв. Өдөр ирэх тусам цахимжуулалт бизнесийн салбарт нэмэгдэж байгаа ба дотоодын болон олон улсын хууль, журмууд нь хил даван ажиллах бизнесүүдийн зохицуулалтыг илүү оновчтой болгох хэрэгтэйг анхааруулав. Ази тивд л гэхэд шинээр 315 бодлого, журам өнгөрсөн онд шинээр нэвтэрсэн нь шинэ энгийн амьдрал, ажил бизнесийг зохицуулахад чиглэжээ.

Тайланд дахь Америкийн Худалдааны Танхимын ТУЗ-ийн гишүүн ноён Жон Эванс бүс нутгийн хамтын ажиллагаанд Монгол Улс илүү идэвхтэй оролцох боломжийн талаар саналаа хэлэхдээ “Монгол Улс байгалийн баялгаа боловсруулах, тухайлбал төмөрийн хүдэр боловсруулж нэмүү өртөг шингэх боломжтой болов уу. Нөгөө талаас Тайланд улсын аялал жуулчлалын салбарт хийсэн судалгааны дүнгээр нийт жуулчдын тоо 35%-иар дахин эргэж сэргэхгүйгээр үгүй болсныг хэллээ. Монгол улс нь Ковидын цар тахлыг амжилттай даван туулж хилээ нээсэн нь аялал жуулчлалын салбарыг сэргээх боломж нээж байгаа бөгөөд хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх нь эдийн засгийн эерэг нөлөөтэй байж болохыг онцоллоо.



Ноён Жон Эванс, Тайланд дахь Америкийн Худалдааны Танхимын ТУЗ-ын гишүүн бөгөөд Tractus Asia компанийн захирал



Уулзалтын төгсгөлд хүндэт панелистууд оролцогч нарын асуултад тухай бүрт нь дэлгэрэнгүй хариулт өгснөөр дугуй ширээний ярилцлагыг өндөрлөлөө

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.